



**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР  
САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

СӨҮЛ ХОТ

2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАСАГ

### I. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ:

#### 1. БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн харилцааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.1.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 14 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр цахимаар, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвд 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 14 гэрээт иргэнийг хамруулан ирсний дараах сургалтыг танхимаар зохион байгуулж дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны танилцуулга
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай
- БНСУ-ын холбогдох хууль, дүрэм журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Ур чадвартай ажиллах хүчний E-7-4 визний талаар
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал гэх мэт.

1.1.2 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2024 оны 11 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **294** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажилласан.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын газраас оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, нутаг буцах зардал, ажил олгогчдоос үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү, Хөдөлмөр, халамжийн корпорациас үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн маргаан шийдэх газар, ажил олгогчдоос олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс зэрэг хэлбэрээр нийт **162,075,008** воныг Монгол Улсын **47** иргэнд олгуулсан.

Хүснэгт 1: Ажил үйлчилгээний төрлөөр иргэдэд олгуулсан мөнгөн дүнгийн жагсаалт

Ажил үйлчилгээний төрөл		Мөнгөн дүн /вон/
Хөдөлмөрийн гэрээт ажилчид	Буцах замын зардал	6,700,620.00
	Цалин, илүү цагийн хөлс	10,657,145.00
	Самсунг даатгал дахь 13 дахь сарын цалин	71,733,100.00
	Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалин	26,242,692.00
	Үйлдвэрлэлийн ослын даатгал	18,432,800.00
Бусад төрлийн виз	Олгогдоогүй, хойшлогдсон цалин хөлс	9,930,000.00
	Үйлдвэрлэлийн ослын даатгал	2,287,520.00
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13 дахь сарын цалин	500,000.00
	Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	15,591,131.00
<b>НИЙТ ОЛГУУЛСАН ДҮН</b>		<b>162,075,008.00</b>

#### 2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаад хугацаа нь дуусаж буй хөдөлмөрийн гэрээт иргэдийг хугацаандаа нутаг буцахад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

1.2.1 Байгууллагын чиг үүрэг, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасны дагуу гэрээт иргэдийн ажлын байранд очиж нөхцөл байдалтай танилцах зорилгоор төвийн дарга болон 4 ажилтны бүрэлдэхүүнтэй баг 2024 оны 11 дүгээр сарын 14-нөөс 15-ны өдрийн хооронд томилолтоор ажиллаж, БНСУ-ын Бусан хотын 우영수산(주) WOoyongsusan ХХК-д ажиллаж байгаа 8, 나래금속(주) NA RAEGEUMSOK ХХК-д ажиллаж байгаа 2, 주식회사광진석재 JUSIKOESAGWANGJINSEOKJAE ХХК-д ажиллаж байгаа 3, нийт 12 хөдөлмөрийн гэрээт ажилчинтай уулзан хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалын зөвлөгөө, мэдээллийг өгч, хөдөлмөрийн аюулгүй байдлын гарын авлага түгээж, хугацаандаа нутаг буцах тухай зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.

1.2.2 Хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусах дөхсөн ажилчдад хугацаандаа нутаг буцах тухай санамж мессежийг 568 хүнд илгээсэн.

**3. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр тогтвор суурьшилтай ажиллан ур чадвартай ажиллах хүчний визний ангилал руу шилжүүлэх ажлын хүрээнд:**

1.3.1 Е-7-4 визний асуудлаар нийт 28 иргэнтэй утас болон цахимаар холбогдож оноо цуглуулах, гэр бүлийн гишүүдийг урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, визний ангиллаа дараагийн ангилал руу өөрчлөх талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, бүртгэлийн санг баяжуулсан.

**4. БНСУ-д оршин сууж байгаа монгол гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж, дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд:**

1.4.1 БНСУ-д ажиллаж амьдарч буй хүүхдүүдийг эх хэл, соёлоо эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв, Монгол Солонгос хэл бичиг соёлын төв НҮТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж амралтын өдрийн сургалтыг зохион байгуулахаар болсон ба сургалтын нээлтийн үйл ажиллагааг 2024 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Сөүл хотын захиргааны байранд зохион байгуулж 120 гаруй оролцогч оролцсон.

1.4.2 БНСУ-д оршин суугаа Монгол Улсын иргэдэд сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх чиглэлээр, ганцаарчилсан сэтгэл засал нийт 4 хүнд, үүнээс нойргүйдэл, сэтгэл гутрал болон сэтгэл түгшилт илрүүлэх сорилыг 1 хүнд, өнгөний сорил 1 хүнд тус тус хийж, дүгнэлт хийж, зөвлөгөө өгсөн.

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСАГ**

**2. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

**1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд хамруулах ажлын хүрээнд:**

2.1.1 Тайлант хугацаанд нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд 87 иргэнийг шинээр хамруулан “Солонгос Улсад гэрээгээр ажиллагсдын программ”-д мэдээллийг бүртгэн гэрээ байгуулсан. Мөн нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэдэд шинээр 87, гэрээний хугацаа сунгасан 18, ажлын байраа сольсон, гэрчилгээг гэж үрэгдүүлсэн, албан байгууллага нь хүсэлт гаргасан 9, нийт 114 даатгуулагчид Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг тус тус бичиж олгосон.

**2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн визний ангиллаар оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах ажлын хүрээнд:**

2.2.1 Нийт 39 иргэнийг сайн дурын нийгмийн даатгалд шинээр хамруулж, БНСУ-ын ААН-д хөдөлмөр эрхэлдэг 50 даатгуулагчийн хүсэлтийн дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг бичиж олгосон.

**3. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, тайлагнах ажлын хүрээнд:**

2.3.1 НДЕГ-ын даргын 2024 оны А/02 дугаар тушаалаар тус тасгийн 2024 оны орлогын батлагдсан төлөвлөгөө 4,997,799,000.00 төгрөг, сар бүрийн орлогын төлөвлөгөө 416,483,250.00 төгрөг болно. Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 57 хувиар биелүүлсэн бөгөөд хүснэгт 2-оор харуулбал:

Хүснэгт 2: Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого	Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний даваа гарагийн хаалтын ханш
		Вон	Төгрөг	Төгрөг	Вон	Төгрөг		
11	416,483,250.00	42,985,000.00	106,602,800.00	130,677,528.00	42,985,000.00	237,280,328.00	57	2.48

2.3.2 Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын ажил олгогчдод тухайн сарын болон өмнөх саруудын 443 ширхэг шимтгэл төлөх нэхэмжлэл факсаар илгээн, нийт 602 даатгуулагчтай шимтгэл төлөхийг сануулж, утсаар холбогдсон.

**2.3.3** Нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн 11 дүгээр сарын шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн сан дахь холбогдох дансанд шилжүүлэн, тайлан мэдээг гарган тус газрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

#### **4. Тэтгэмж авах эрх үүссэн даатгуулагчдад баримт олгох ажлын хүрээнд:**

**2.4.1** Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцөлийг хангасан, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүссэн 11 даатгуулагчид шаардлагатай бичиг баримтыг Монгол хэлнээ хөрвүүлж, зохих журмын дагуу даатгуулагчийн тодорхойлолтыг гаргаж өгсөн.

#### **5. Иргэд, даатгуулагчид болон ажил олгогчдод нийгмийн даатгалын талаар мэдээлэл, заавар, зөвлөгөө өгөх, тэдний хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд:**

**2.5.1** Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 537, үүнээс 497 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 40 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажилласан. Мөн БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвд ирсний дараах сургалтыг 11 дүгээр сарын 21-ний өдөр танхимаар зохион байгуулж 15 гэрээт иргэнд, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн тухай сургалтыг зохион байгуулж, сурталчилгааны материал тарааж ажилласан. Мөн 11 дүгээр сарын 10, 18-ны өдөр Ансан болон Чонжү хотноо 2 удаагийн “Явуулын үйлчилгээ”-г үзүүлж, 65 иргэнд төвийн танилцуулга, нийгмийн даатгалын тухай тараах материал тарааж, 53 иргэн, даатгуулагчид нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн тухай мэдээлэл, зөвлөгөөг өгсөн.

#### **6. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанаас шимтгэлийн буцаан олголтыг олгуулах ажлын хүрээнд:**

**2.6.1** БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар хүсэлт ирүүлж УТА-д илгээсэн 207, 208 дугаар ээлжийн 3 иргэний хүсэлтийг шийдвэрлэж 23,342,240.00 воныг олгуулсан. Мөн төлсөн шимтгэлээ буцааж авахаар хүсэлт ирүүлсэн 211, 212 дугаар ээлжийн 3 иргэний бичиг баримтыг БНСУ-ын УТА-ны холбогдох мэргэжилтэнд хүргүүлж, хариуг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

### **3. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ**

#### **1. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сахилга хариуцлагыг чангатгах, ажлын бүтээмж, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн ажлын хүрээнд:**

**3.1.1** Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 18 удаа, байгууллагын <https://seoulcenter.mlsp.gov.mn> цахим хуудсанд 15 удаагийн мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар 29,955 орчим хандалт авсан.

Е-7-4 визийн асуудлаар Солонгосын Хууль зүйн яамны харьяа Гадаадын иргэн харьяатын албаны 1345 лавлах төвийн зөвлөх Ц.Цэнд-Аюуштай ярилцлага хийж төвийн вебсайт, сошиал хуудсанд нийтэлсэн ба 14,218 хүнд хүрсэн. Мөн ур чадвартай ажилчны виз мэдүүлэх журамд орсон өөрчлөлтийн мэдээг орчуулан, постер бэлтгэж мэдээлсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой санамж зөвлөгөөг долоо хоног бүрийн баасан гарагт цувралаар нийтэлж байна.

БНСУ-д оршин сууж буй Монгол гэр бүлүүд хамрагдах боломжтой хөнгөлөлтүүдийн талаар мэдээллийг орчуулан бэлтгэж төвийн цахим хуудаст нийтэлсэн.

Хөдөлмөрийн гэрээт Е-9 визээр ажиллаж буй гадаад ажилчны заавал даатгуулах даатгалуудын талаарх ярилцлагыг бэлтгэж төвийн цахим хуудсанд нийтэлсэн.

**3.1.2** БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны харьяа сургалт, судалгааны институттэй хамтран 2024 онд шинээр мөрдөгдөж буй БНСУ-ын хууль эрх зүйн мэдээлэл авах, дүрэм журмын өөрчлөлттэй танилцах нийт 2 цагийн мэргэшүүлэх сургалтад төвийн нийт албан хаагчдыг хамруулав. 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулсан тус сургалтаар “Аж ахуйн нэгжүүдийн мэдэж байх хөдөлмөрийн тухай хууль, дүрэм”, “Түгээмэл тулгардаг асуудал ба бодит жишээ” багц сэдвүүдээр мэдээлэл өгч, оролцогчдод батламж гардуулсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн албан хаагчид Сөүл хотын Олон соёл хариуцсан хэлтэст 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр зочилж, гадаад иргэдэд чиглэсэн бодлого төлөвлөлт, үйл ажиллагаатай танилцав. Олон соёлын хэлтэс нь гадаад иргэдийг дэмжих, олон соёлт гэр бүлийн ажил эрхлэлтийг дэмжих, хүүхдүүдийн боловсрол хүмүүжлийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг ба энэ удаагийн уулзалтаар хоёр тал цаашид олон талаар хамтран ажиллахаар хэлэлцсэн.

Вьетнам улсын хөдөлмөрийн гэрээт иргэд хариуцсан EPS төвтэй танилцаж, туршлага хуваалцах уулзалтыг 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан.

БНСУ-д хууль бусаар оршин сууж буй болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах боломжгүй монгол иргэдийг эрүүл мэндийн үнэ төлбөргүй үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа ба энэ хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр “Хүмүүнлэг нийгэм” эмч нарын сайн дурын байгууллагатай, 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Сөүлийн эрүүл мэндийн сайн дурын сантай уулзалт зохион байгуулсан.

**3.1.3** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн албан хаагчдын бэлтгэсэн гарын авлагаар мэдлэг хуваалцах сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулсан.

**3.1.4** БНСУ-тай байгуулах Чөлөөт худалдааны хэлэлцээртэй холбогдуулан ЭЗХЯ-ГБХНХЯ хоорондын мэдээлэл солилцох уулзалтад оролцож мэдээлэл солилцсон. Уулзалтын үеэр тавьсан хүсэлтийн дагуу БНСУ-д ажиллаж, амьдарч, бизнес эрхэлж буй монгол иргэдийн талаарх мэдээлэл, визний ангиллаар, ажиллаж буй салбарын ангиллаар судалгаа гарган илгээсэн.

**3.1.5** Нийгмийн даатгалын аппликейшнд бүртгүүлэх 26 иргэний хүсэлтийг хүлээн авч, бүртгэлийг баталгаажуулан, иргэдэд бүртгүүлэх кодыг холбогдох программаас илгээв. Мөн нийгмийн даатгалын лавлагаа авах хүсэлт гаргасан 88 иргэний хүсэлтийн дагуу мэдээллийг холбогдох программаас гаргаж өгөв.

**3.1.6** Төрийн албанаас зохион байгуулсан 7:4:10 сургалтад тасгийн нийт албан хаагчид 2 удаа хамрагдсан.